

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	2
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ,
ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ОДОНТУЯА ТАНАА

дэд.од. 24 № ЧБА.2022/182/НА - СТА - ТМЗ
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200196

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,966,130.00	93,626,687.20
35	БАРАА МАТЕРИАЛ	88,966,130.00	93,626,687.20
35400	Хангамжийн материал	88,966,130.00	93,626,687.20
35410	Бичиг хэргийн материал		10,800.00
35420	Аж ахуйн материал		108,000.00
35470	Бусад хангамжийн материал	88,966,130.00	93,507,887.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,592,392,050.92	3,519,526,537.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,592,392,050.92	3,519,526,537.77
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	3,559,356,495.32	3,493,984,315.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,406,200,000	3,416,135,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,846,666.64)	(94,616,666.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0	0
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	104,707,400.00	117,932,270.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,389,478.52)	(41,683,226.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,535,537.00	114,853,537.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,229,676.52)	(26,955,692.92)
39217	Ном	2,379,380.00	8,318,594.58
39300	Биет бус хөрөнгө	33,035,555.60	25,542,222.32
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(244,444.40)	(537,777.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,600,000.00)	(10,800,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,681,358,180.92	3,613,153,224.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,681,358,180.92	3,613,153,224.97
51	Засгийн газрын хувь оролцоо	3,681,358,180.92	3,613,153,224.97
51200	Хуримтлагдсан үр дүн	3,681,358,180.92	3,613,153,224.97
51210	Өмнөх үеийн үр дүн	3,681,358,180.92	3,681,358,180.92
51220	Тайлант үеийн үр дүн	0	(68,204,955.95)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0	0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,681,358,180.92	3,613,153,224.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,187,023,630.00	464,768,100.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,890,023,630.00	455,388,100.78
120	Нийтлэг татварын бус орлого	3,509,177,330.00	34,124,231.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,472,467,000.00	33,591,684.58
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,472,467,000.00	33,591,684.58
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	36,710,330.00	532,547.20
	Тусламжийн орлого	165,164,600.00	175,859,369.00
122005	Төсвөөс санхүүжих	165,164,600.00	175,859,369.00
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	215,681,700.00	245,404,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	215,681,700.00	245,404,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,000,000.00	9,380,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,000,000.00	9,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	297,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,380,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	505,665,449.08	532,973,056.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,665,449.08	532,973,056.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,516,483.40	531,039,895.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,312,064.00	202,205,961.00
210101	Үндсэн цалин	157,039,383.00	186,133,436.00
210102	Нэмэгдэл	6,701,900.00	6,701,900.00
210104	Урамшуулал	13,570,781.00	9,370,625.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,569,412.93	25,433,268.25
210201	Тэтгэврийн даатгал	14,445,812.93	17,342,970.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,780,900.00	2,022,599.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,424,700.00	1,618,099.97
210204	Ажилгүйдлийн даатгал	356,200.00	404,499.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,561,800.00	4,045,099.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,392,069.39	175,859,369.00
210301	Гэрэл, цахилгаан	2,589,425.39	3,780,884.00
210302	Түлш, халаалт	157,363,440.00	167,854,339.00

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	4,439,204.00	4,224,146
2104	Хангамж, бараа материалын зардал	4,165,880.00	6,139,700.00
210401	Бичиг хэрэг	1,499,080.00	1,499,450.00
210402	Тээвэр, шатахуун	544,300.00	546,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	988,100.00	993,900.00
210404	Ном, хэвлэлийн зардал	0	24,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,400	2,275,460.00
2107	Томилолт, зочны зардал	7,703,000.00	395,000.00
210702	Дотоод албан томилолт	7,703,000.00	395,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,617,900.00	4,846,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,617,900.00	3,892,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		604,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс		350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,756,166.08	116,159,797.73
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	35,445,900.00	8,876,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,310,266.08	107,283,097.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,148,956.68	1,933,160.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,000,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	0
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	772,793.61	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	772,530.61	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	263.00	0
	Төсвийн захирагчдаас олгох санхүүжилт	2,376,163.07	1,933,160.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,376,163.07	1,933,160.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,681,358,180.92	(68,204,955.95)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,681,358,180.92	(68,204,955.95)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	677,846,300.00	430,643,869.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	380,846,300.00	421,263,869.00
	Тусламжийн орлого	165,164,600.00	175,859,369.00
122005	Төсвөөс санхүүжих	165,164,600.00	175,859,369.00
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	215,681,700.00	245,404,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	215,681,700.00	245,404,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,000,000.00	9,380,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,000,000.00	9,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	297,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,380,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	611,924,300.00	430,643,869.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611,924,300.00	430,643,869.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,775,343.32	428,710,708.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,312,064.00	202,205,961.00
210101	Үндсэн цалин	157,039,383.00	186,133,436.00
210102	Нэмэгдэл	6,701,900.00	6,701,900.00
210104	Урамшуулал	13,570,781.00	9,370,625.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,569,412.93	25,433,268.25
210201	Тэтгэврийн даатгал	14,445,812.93	17,342,970.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,780,900.00	2,022,599.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,424,700.00	1,618,099.97
210204	Ажилгүйдлийн даатгал	356,200.00	404,499.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,561,800.00	4,045,099.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,392,069.39	175,859,369.00
210301	Гэрэл, цахилгаан	2,589,425.39	3,780,884.00
210302	Түлш, халаалт	157,363,440.00	167,854,339.00
210303	Цэвэр, бохир ус	4,439,204.00	4,224,146.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,686,060.00	8,807,810.00
210401	Бичиг хэрэг	1,499,080.00	1,499,450.00
210402	Тээвэр, шатахуун	544,300.00	546,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	988,100.00	993,900.00
210404	Ном, хэвлэлийн зардал	2,379,380.00	849,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,275,200.00	4,117,670.00
2105	Нормативт зардал	942,000.00	950,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	942,000.00	950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,429,937.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,014,900.00	0

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210602	Тавилга	70,415,037.00	0
2107	Томилолт, зочны зардал	7,703,000.00	395,000.00
210702	Дотоод албан томилолт	7,703,000.00	395,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,497,900.00	4,846,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,617,900.00	3,892,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		604,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,242,900.00	10,212,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,242,900.00	10,212,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,148,956.68	1,933,160.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,000,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	0
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	772,793.61	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	772,530.61	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	263.00	0
	Төсвийн захирагчдаас олгох санхүүжилт, шилжүүлэг	2,376,163.07	1,933,160.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,376,163.07	1,933,160.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	65,922,000.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	65,922,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,922,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	65,922,000.00	0
223001	Бусад хөрөнгө	65,922,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	65,922,000.00	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,681,358,180.92	3,681,358,180.92
9	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,681,358,180.92	3,681,358,180.92
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,681,358,180.92	3,681,358,180.92
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
16	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-68,204,955.95	-68,204,955.95
17	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	3,613,153,224.97	3,613,153,224.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,114,800.00	421,263,869.00	3,850,931.00	99.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,114,800.00	421,263,869.00	3,850,931.00	99.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,114,800.00	419,330,708.25	5,784,091.75	98.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,256,900.00	202,205,961.00	50,939.00	100.0%
210101	Үндсэн цалин	186,155,000.00	186,133,436.00	21,564.00	100.0%
210102	Нэмэгдэл	6,701,900.00	6,701,900.00		100.0%
210104	Урамшуулал	9,400,000.00	9,370,625.00	29,375.00	99.7%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,304,700.00	25,433,268.25	1,871,431.75	93.1%
210201	Тэтгэврийн даатгал	19,214,400.00	17,342,970.03	1,871,429.97	90.3%
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,600.00	2,022,599.03	0.97	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,618,100.00	1,618,099.97	0.03	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	404,500.00	404,499.74	0.26	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,045,100.00	4,045,099.48	0.52	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,710,300.00	175,859,369.00	3,850,931.00	97.9%
210301	Гэрэл, цахилгаан	4,926,000.00	3,780,884.00	1,145,116.00	76.8%
210302	Түлш, халаалт	167,854,300.00	167,854,339.00	(39.00)	100.0%
210303	Цэвэр, бохир ус	6,930,000.00	4,224,146.00	2,705,854.00	61.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,450,000.00	6,439,810.00	10,190.00	99.8%
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,499,450.00	550.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	546,890.00	3,110.00	99.4%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	993,900.00	6,100.00	99.4%
210404	Ном, хэвлэлийн зардал	850,000.00	849,900.00	100.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00	0	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,750,000.00	1,749,670.00	330.00	100.0%
2105	Нормативт зардал	950,000.00	950,000.00	0	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	950,000.00	950,000.00	0	100.0%
2107	Томилолт, зочны зардал	395,300.00	395,000.00	300.00	99.9%
210702	Дотоод албан томилолт	395,300.00	395,000.00	300.00	99.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	954,800.00	954,800.00	0	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00	0	100.0%

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,092,800.00	7,092,500.00	300.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,092,800.00	7,092,500.00	300.00	100.0%
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,933,160.75	(1,933,160.75)	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,933,160.75	(1,933,160.75)	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,933,160.75	(1,933,160.75)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	425,114,800.00	421,263,869.00	3,850,931.00	99.1%
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	425,114,800.00	421,263,869.00	3,850,931.00	99.1%
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	245,404,500.00	245,404,500.00	0	100.0%
122005	Төсвөөс санхүүжих	179,710,300.00	175,859,369.00	3,850,931.00	97.9%
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
	Төсвийн бусад мэдээллийн ангилал				
	Байгууллагын тоо				
	Ажиллагсдын тоо	22.00	22.00		100.0%
	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00		100.0%
	Үйлчлэх ажилтан	8.00	8.00		100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	2,368,000.00	2,368,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,368,000.00	2,368,000.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,892,000.00	3,892,000.00	0.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,892,000.00	3,892,000.00	0.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,120,000.00	3,120,000.00	0.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,120,000.00	3,120,000.00	0.00	100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
31	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,380,000.00	9,380,000.00	0.00	100.0%
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв нь хүүхэд, залуучуудын тасралтгүй хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, амьдрах ухаан, насан туршийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 505,665.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,056.6 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 532,973.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,329.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,263.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,204.9 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан Бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	88,966.1	93,626.7	4,660.6
Үндсэн хөрөнгө	3,592,392.0	3,519,526.5	(72,865.55)
Нийт хөрөнгө	3,681,358.2	3,613,153.2	(68,205)
Өр төлбөр	0	0	0
Өмнөх үеийн үр дүн	3,681,358.2	3,681,358.2	0
Тайлант үеийн үр дүн	0	(68,204.9)	(68,204.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,681,358.2	3,613,153.2	(68,205)

Бараа материалын дансны үлдэгдэл 93,626.7 мянган төгрөг болж 4,660.6 мянган төгрөгөөр өссөнд бусад хангамжийн материалын өсөлт голчлон нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Бараа материалын зардлын дансны эцсийн үлдэгдлийн дийлэнх хувь буюу 99.8 хувь бусад хангамжийн материалын зардал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,519,526.5 мянган төгрөг болж 72,865.55 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 825.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 33,591.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. 2021 онд үндсэн хөрөнгө акталж устгасан байхгүй болно.

Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн 3,613,153.2 мянган төгрөг болж 68,205 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь 2021 оны үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,722,225.5 мянган төгрөгөөр буюу 88.8 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх онд үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгө, бараа материалын орлогоос шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 27,307.7 мянган төгрөгөөр буюу 5,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд голлон нөлөөлсөн цалин хөлс, болон нэмэгдэл урамшууллын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд байна. Энэ нь тус байгууллага нь өмнөх оны 2 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тайлант оны хичээлийн жилд бүрэн үйл ажиллагаа явуулсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 358,870.4 мянга, орон нутгийн төсвөөс 188,674.1 мянга, нийт 547,544.5 мянган төгрөгөөр зардлыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвөөс санхүүжилт 113,465.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 8,963.8 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 245,404.5 мянга, орон нутгийн төсвөөс 179,710.3 мянга, нийт 425,114.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх ерөнхий боловсрол хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал болон тогтмол зардлын арга хэмжээг санхүүжүүлэхээр 425,114.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 245,404.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 179,710.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 245,404.5 мянга, орон нутгийн төсвөөс 175,859.4 мянга, нийт 421,263.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 419,330.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсөвт 1,933.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421,263.9 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,380.0 мянга, нийт 9,380.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс зардалд 2,368.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардалд 3,892.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,120.0 мянга, нийт 9,380.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроож мэдээлсэн 13 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 241.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв. Үүнд:

4.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчин Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн үйлчлэгч Д.Бадамжавд сахилгын шийтгэл тооцох хугацаа дуусаагүй байхад 3, 4-р улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 241.9 мянган төгрөг олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв	1	241.9			1	241.9				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 22-ны өдөр